



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/299

Улаанбаатар хот

Г Г
Эмч томилолтоор ажиллуулах, сургалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.13 дахь заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх, хүүхдийн эндэгдэл өндөр байгаа аймгуудад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон нийслэлийн амаржих газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, нярайн эмч нарыг нэг сарын хугацаатай томилолтоор ажиллуулсугай.

2. Эмч томилолтоор ажиллуулах удирдамжийг нэгдүгээр, хөдөө орон нутагт томилолтоор ажиллах болон орон нутгаас солилцон ажиллах эмч нарын нэрсийг хоёрдугаар, эмч нарын томилолт, замын зардлын төсвийг гуравдугаар, эмч нартай байгуулах гэрээний загварыг дөрөвдүгээр, "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, нярайн сувилагчийг чадавхжуулах сургалтын удирдамжийг тавдугаар, "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, нярайн сувилагчийг чадавхжуулах сургалтын төсвийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Улаанбаатар хот болон орон нутагт нэг сарын хугацаатай томилогдон ажиллах эмч нарт олгох урамшуулал, томилолтын зардалд зарцуулах 44,910,000 (дөчин дөрвөн сая есөн зуун арван мянган), замын зардалд зарцуулагдах 15,446,240 (арван таван сая дөрвөн зуун дөчин зургаан мянга хоёр зуун дөчин), Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, нярайн сувилагчийг чадавхжуулах сургалтын зардал 6.690,930 (зургаан сая, зургаан зуун ерэн мянга есөн зуун гуч), төгрөг нийт 67,047,170 (жаран долоон сая дөчин долоон мянга нэг зуун далан) төгрөгийг 2016 онд батлагдсан эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны сургалтын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Ч.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Томилолтоор ажиллаж байгаа эмч нарын цалинг үндсэн байгууллагаас нь олгохыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт, Улаанбаатар хотоос орон нутаг ажиллах эмч нарын байр, хоолны зардлыг хүлээн авч байгаа орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь хариуцахыг аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.

081140

6. Томилолтоор орон нутагт ажиллах өмч нартай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-т, "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, нярайн сувилагчийг чадавхжуулах сургалт"-ыг чанартай зохион байгуулахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн төв (Ш.Энхтөр)-д, тус тус даалгасугай.

6. Энэ тушаал гарч буйтай холбогдуулан "Сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай ЭМСС-ын 2016 оны А/111-р тушаалын 4-р хавсралтын 25-д заасан Эрүүл мэндийн ажилтны гадаад сургалтын зардлыг 338,000,000 (гурван гучин найман сая) болгон өөрчилж, уг хавсралтын 18-д заасан ажлын байрны сургалтын зардал дээр 90,000,000 (ерэн сая) төгрөгийг шилжүүлсүгэй.

7. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д тус тус даалгасугай.

САЙД



С.ЛАМБАА



ЭМЧ ТОМИЛОЛТООР АЖИЛЛУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго:

Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, орон нутгийн эмч, мэргэжилтнийг ажлын байран дээр нь сургаж, дадлагажуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, харилцан туршлага солилцох.

Ажиллах хугацаа: 2016 оны 3-р улиралд

Эмч томилолтоор ажиллуулах эрүүл мэндийн байгууллага:

Орон нутагт: ЭХЭМҮТ, Өргөө, Амгалан амаржих газар, Интермед, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв

Улаанбаатар хотод: Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Ховд, Хөвсгөл

Үйл ажиллагаа:

Орон нутагт ажиллах эмч нар дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

1. Мэргэжлийн чиглэлээр эмчлэгч эмчийн үүрэг гүйцэтгэнэ.
2. Орон нутагт ажиллахдаа эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ болон тухайн байгууллагын дотоод журмыг чанд баримтлан ажиллана.
3. Тухайн эмнэлгийн эмч нарын хурал, тойрон болон хамтарсан үзлэгт оролцож, зөвөлгөө өгч, туршлагаа хуваалцана.
4. Ажлын байран дээр мэргэжлийн чиглэлээр сургалт явуулж, дадлагажуулна.
5. Эх, хүүхдийн эндэгдлийн эмнэлзүй-эмгэг судлалын болон эхийн ноцтой хүндрэлийг хэлэлцэх хуралд оролцоно.
6. Эх, хүүхдийн тусламжид ашиглаж буй нэн шаардлагатай эм, тариаг зааврын дагуу хэрэглэх, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг бүрэн, зөв ашиглахад эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургана.
7. Шаардлагатай тохиолдолд жижүүрт гарч, алсын дуудлагад явна.
8. Ноцтой хүндэрсэн бие даан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд ЭХЭМҮТ болон бусад лавлагаа төвүүдээс цахимаар зөвөлгөө авна.

Улаанбаатар хотод ажиллах эмч нар дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

1. Тасгийн эрхлэгчийн удирдлага дор ажиллана.
2. Тухайн эмнэлэгт ажиллахдаа эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ болон тухайн байгууллагын дотоод журмыг чанд баримтлан ажиллана.
3. Оношилгоо, эмчилгээнд идэвхтэй оролцож, бие даан дагалдан суралцана.
4. Шаардлагатай тохиолдолд жижүүрт гарна.
5. Шинээр олж авсан мэдлэг, ур чадвар, туршлагыг орон нутагтаа хэрэгжүүлэх, бусад эмч нартаа зааж сургах үйл ажиллагааг зохион байгуулна.

Санхүүжилт:

Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийг дэмжих зардал

Гарах үр дүн:

1. Эх, нярай, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар сайжирна.
2. Эмч, эх баригч, сувилагч нарын мэдлэг, тусламжийг гардан үзүүлэх ур чадвар нэмэгдэнэ.

Тайлагналт:

Томилолтоор болон солилцон ажилласан бүх эмч нар хийсэн ажлын тайланг томилолт дууссанаас хойш 7 хоногийн дотор өөрийн байгууллага болон ЭМСЯ-ны Эмнэлгийн тусламжийн хэлтэст бичгээр ирүүлнэ.

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны ... сарын ... өдрийн
... дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



1. УЛААНБААТАР ХОТООС СРОН НУТАГТ АЖИЛЛАХ ЭМЧ НАРЫН НЭРС, АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Ажиллах аймгийн нэр	Эх, барих эмэгтэйчүүдийн эмч		Хүүхдийн эмч		Нярайн эмч		Эрчимт эмчилгээ Сэхээн амьдруулах	
		Эмчийн нэр, ажлын газар	Эхлэх огноо	Эмчийн нэр, ажлын газар	Эхлэх огноо	Эмчийн нэр, ажлын газар	Эхлэх огноо	Эмчийн нэр, ажлын газар	Эхлэх огноо
1.	Баян - Өлгий	М.Камара, ЭХЭМҮТ	18/VII (30 хоног)	Б.Ариунхишиг ЭХЭМҮТ	10/VIII (30 хоног)	Г.Оюумаа ЭХЭМҮТ	10/VIII (30 хоног)		
2.	Баянхонгор	Б.Батхишиг, ЭХЭМҮТ	18/VII (30 хоног)	Ж. Эрдэнэбаатар ЭХЭМҮТ	18/VII (30 хоног)				
3.	Завхан	-		Энхзул ЭХЭМҮТ	15/VII (30 хоног)	Д.Гэрэлтуяа ЭХЭМҮТ	15/X (30 хоног)		
4.	Өвөрхангай	Б Оюунчулуун Эргөө амаржих	18/VII (30 хоног)	Ц.Пүрэвсүрэн ЭХЭМҮТ	1/VII (30 хоног)				
5.	Өмнөговь	Б Баасанхүү ЭХЭМҮТ							
6.	Сэлэнгэ	Б Даваацэцэг Амгалан амаржих	18/VII (30 хоног)	Б.Чинбат ЭХЭМҮТ	1/VIII (30 хоног)	Л.Ролзодмаа ЭХЭМҮТ	1/VIII (30 хоног)		
7.	Увс	-		Лхагвагарам ЭХЭМҮТ	1/VIII (30 хоног)				
8.	Ховд	Х Цолмон ЭХЭМҮТ	18/VII (30 хоног)	С.Очир ЭХЭМҮТ	1/VII (30 хоног)	Д.Отгонбат ЭХЭМҮТ	1/VIII (30 хоног)		
9.	Хөвсгөл	Орхон БОЭТ	18/VII (30 хоног)	Д.Гэрэлмаа Интер мед	22/VIII (30 хоног)			Т.Хаш-Эрдэнэ ЭХЭМҮТ	1/VIII (30 хоног)

2. ЭХЭМҮТ, АМАРЖИХ ГАЗРУУДАД ОРХОН НУТГААС ИРЖ АЖИЛЛАХ ЭМЧ НАРЫН НЭРС, АЖИЛЛАХ ХУБААРЬ

№	Эмч ирүүлэх аймгийн нэр	Эх, барих эмэгтэйчүүдийн эмч		Хүүхдийн эмч		Нярайн эмч	
		Эмчийн нэр, ажиллах эмнэлэг	Эхлэх огноо	Эмчийн нэр, ажиллах эмнэлэг	Эхлэх огноо	Эмчийн нэр, ажиллах эмнэлэг	Эхлэх огноо
1.	Баян - Өлгий	Т.Жанболат	18/VII (30 хснэг)	К.Аяужан	10/VIII (30 хоног)	-	
2.	Баянхонгор	М.Болорчимэг ЭХЭМҮТ	(30 хснэг)	Ч.Жавхлан ЭХЭМҮТ	10/VII (30 хоног)	-	
3.	Завхан	-		Л.Отгонжаргал ЭХЭМҮТ	1/VIII (30 хоног)	Д.Мянганзул ЭХЭМҮТ	15/VII
4.	Өвөрхангай	Д.Баярмаа Өргөө АГ	(30 хснэг)	Д.Тогтохдулам ЭХЭМҮТ	15/VII (30 хоног)	-	
5.	Өмнөговь	С.Нандинцэцэг ЭХЭМҮТ	(30 хснэг)	-	1/VII (30 хоног)	-	
6.	Увс	-		З. Сүрэнхүү ЭХЭМҮТ			
7.	Ховд	Доржханд ЭХЭМҮТ	(30 хснэг)	Бадамжав ЭХЭМҮТ	1/VIII (30 хоног)	Солонго ЭХЭМҮТ	
8.	Хөвсгөл	Ганболд Орхон БОЭТ	(30 хснэг)	-	1/VII	-	1/VIII
9.	Сэлэнгэ	-		Б.Оюунчимэг ЭХЭМҮТ			

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны ... сарын ... өдрийн
... дугаар тушаалын 4 дүгээр
хавсралт



ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ЭМЧТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

.....оны-р сарын-ны өдөр

№.....

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэнд, спортын яам (цаашид гэх)-ийг төлөөлж Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга с.энхболд..... овогтой нөгөө талаас..... аймаг/нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга овогтой аймаг/дүүргийн эмнэлэгт их эмч/сувилагч/бусад мэргэжилтэн ажилтай овогтой (РД.....) /цаашид суралцагч гэх/ нар нь Эрүүл мэндийн сайд, спортын садын 2016 оны тушаалыг үндэслэл болгон мэргэжлээр 1 сарын хугацаатай аймагт томилолтоор ажиллах харилцааг тохиролцон байгуулав.
- 1.2 Томилолтын хугацаанд гэрээ байгуулагч талуудын хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээнээс гадна бусад хууль, журмын хүрээнд зохицуулна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Эх, хүүхдийн эндэгдэл өндөр байгаа аймгуудад ЭХЭМҮТ болон нийслэлийн амаржих газруудаас эх, барих эмэгтэйчүүд, хүүхэд, нярайн эмч нар орон нутагт 1 сарын хугацаатай томилолтоор ажиллуулж орон нутгийн эх, хүүхдийн эрүүл мэндийн туслаж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. ЭМСЯ-ны эрх:

- 3.1.1 Орон нутагт/нийслэлд томилолтоор ажиллах эмчийг захиалагч аймгуудад хуваарилах,
3.1.2 Томилолттой холбоотой мэдээ, тайланг хүлээн авагч эрүүл мэндийн байгууллага, томилолтоор ажилласан эмчээс гаргуулан авах,
3.1.3 Эмч солилцооны үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтанд хандах,

3.1.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагч эрүүл мэндийн байгууллага, томилолтоор ажиллаж буй эмч нараас шаардах.

3.2 ЭМСЯ-ны үүрэг:

3.2.1 Томилолтоор ажиллаж буй эмчид урамшуулал 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн 80%-ийг гэрээ байгуулсан өдөр, үлдсэн 20%-ийг тайлан хамгаалсны дараа олгох,

3.2.2 Хөдөө орон нутгаас ирсэн эмчид томлолтын зардал олгох,

3.2.3 Томилолттой холбоотой асуудлаар заавар, зөвлөлгөө өгч, эмч болон захиалагч эрүүл мэндийн байгууллагын хооронд үүссэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх

3.3 Захиалагч эрүүл мэндийн байгууллагын эрх:

3.3.1 Нийслэлээс гэрээгээр ажиллаж буй эмчтэй холбоотой мэдээллийг авах

3.3.2 Нийслэлээс гэрээгээр ажиллаж буй эмч гэрээт хугацаагаа дуусгаагүй тохиолдолд энэ талаар ЭМСЯ-д мэдээлэх, хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэх эсвэл холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

3.4 Захиалагч эрүүл мэндийн байгууллагын үүрэг:

3.4.1 Өгсөн захиалгын дагуу нийслэлээс ирж ажиллаж буй эмчийг орон байраар хангах,

3.4.2 Жижүүр эмчийн үүрэг гүйцэтгэх, дуудлагаар ажилласан тохиолдолд зохих хөлс урамшуулдлыг олгох,

3.4.3 ажиллаха болон ЭМХТ-өөс хуваарилсан мэргэшлийн чиглэлийн дагуу мэргэжилтнээ сургах,

3.4.4 Ажиллах боломжоор хангаж, захиалагч эрүүл мэндийн байгууллагаас шалтгаалан ажлыг тасалдуулахгүй байх.

3.4.5 Гэрээний хугацаа дүүссэн тохиолдолд томилолтоор ажилласан эмчийн тайланг хянаж, тодорхойлолт гаргах.

3.4 Томилолтоор ажиллаж буй эмчийн эрх:

3.4.1 Томилолтоор ажиллах хугацааны цалин хөлсийг авах,

3.5 Томилолтоор ажиллаж буй эмчийн үүрэг:

3.5.1 ЭМС-ын сайдын ... тушаалаар баталсан удирдамжийг мөрдөж ажиллах,

3.5.2 Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ажлаа чанартай гүйцэтгэх,

3.5.3 Шаптгаангүйгээр ажил таслахгүй суралцаж, томилолтын хугацааг бүрэн дуусгах,

3.5.4 Эмчилгээ оношилгооны удирдамж, стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах

ДӨРӨВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, албан ёсоор чөлөө аваагүй болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил орхисон эмч нь төсвөөс урамшуулал тэтгэлэг, замын зардлыг ЭМСЯ-д, захиалагч байгууллагаас олгосон урамшуулал, бусад санхүүжилтийг тухайн байгууллагад тус тус буцаан төлж барагдуулна.

4.2 Ажлын байранд хариуцлага алдаж эмчнэлгийн мэргэжилтний ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргавал хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ

ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв шийдвэрлэж чадахгүй тохиолдолд маргааныг шүүхийн байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлнэ.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

I. Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Энхболд
..... овогтой
..... (гарын үсэг)

I. ЗАХИАЛАГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН
ДАРГА/ЗАХИРАЛ
..... овогтой
..... (гарын үсэг)

II. СУРАЛЦАГЧ:

..... аймаг/ нийслэлийн эмнэлгийн
..... их эмч/сувилагч/бусад мэргэжилтэн ажилтай
..... овогтой
..... (гарын үсэг)
(РД:, Утас:)



Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж,
нярайн сувилагчийг чадавхжуулах сургалтын удирдамж

Үндэслэл:

Монгол улсад 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 97.2 байсан бол 2015 онд 18.3 болж 4,8 дахин буурсан. 2015 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 63,4% нялхсын эндэгдэл, 55,8% нярайн эндэгдэл байгаагаас харахад тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулахын тулд нялхсын эндэгдэл, нярайн эндэгдлийг бууруулах асуудал чухал бөгөөд төрөлтөнд оролцож буй мэргэжилтнүүдийг чадавхижуулах нь шаардлагатай. Иймд төрөх тасаг төрөх өрөөнд ажиллаж буй нярайн сувилагчийн мэдлэг ур чадварыг сайжруулах шаардлагатай байгаа тул бүх аймгийн төрөх тасгийн сувилагч нарт "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж"-ийн сургалтыг зохион байгуулах зорилгоор энэхүү удирдамжийг боловсрууллаа.

Зохион байгуулах байгууллага: Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв.

Оролцогсад: Бүх аймгийн нярайн болон төрөх тасгийн сувилагч нар.

Үйл ажиллагааны чиглэл: ЭХЭМҮТ-өөс 1 сургагч багш-сувилагч орон нутагт очиж НЭҮНШТ, нярайн сэхээн амьдруулалт болон ялангуяа нярайг амьсгалахад туслах зэрэг ур чадвар дадал олгох сургалтыг нярайн болон төрөх тасгийн сувилагч нарт зохион байгуулна.

Сургалтын агуулга:

- ✓ Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн талаар онолын шинэ мэдлэгтэй болох
- ✓ Төрөх өрөөнд нярайд тусламжийг зөв үзүүлж чаддаг болох
- ✓ Амьсгалж байгаа болон амьсгалахгүй байгаа нярайд хурдан шуурхай тусламж үзүүлэх ур чадвартай болох
- ✓ Мэс заслын эмгэгтэй төрсөн нярайн сувилгаа хийх
- ✓ Нярайд өргөн хэрэглэгдэх орчин үеийн тоног төхөөрөмжийг ажиллуулж чаддаг байх
- ✓ Дутуу болон бага жинтэй төрсөн нярайн онцлог асаргаа сувилгаа

Шаадлагатай төсөв:

6.690,930 (зургаан сая, зургаан зуун ерэн мянга есөн зуун гуч) төгрөг.

Хугацаа: 2016 оны 7-9 сар

Хүлээгдэж буй үр дүн:

1. Нярайн сувилагч нар нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг зөв төгс хийж чаддаг болох
2. Өвчлөл эндэгдлийн гол шалтгаан болсон бүтэлттэй төрсөн нярайн сэхээн амьдруулалтыг цаг алдалгүй хурдан шуурхай үзүүлдэг болох
3. Эндэгдэл өвчлөл өндөртэй дутуу болон бага жинтэй нярайн асаргаа, сувилгаа хамгаалах дэглэмийн талаар онолын болон дадлагын мэдлэг чадвараа дээшлүүлэх
4. Нярайд өргөн хэрэглэгдэх тоног төхөөрөмжийг зөв ажиллуулж чаддаг болох.